

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 35
1.	<i>Монгол Улсын Ес зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцэх</i>	5 – 26
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай/</i>	26 – 35

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу;  
Чөлөөтэй: Б.Жавхлан.*

**Нэг.Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцэх**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор Ш.Батсүх, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор Ч.Эрдэнэчимэг, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Үнэлгээ, мониторингийн газрын референт А.Амармэнд нар байлцав.

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс танилцуулав.

Монгол Улсын Ёс зүйн хорооны тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Хэрлэн, Г.Очирбат нарын тавьсан асуултад Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Энхтуяа, Б.Хэрлэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг сонсов.

*Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор Ш.Батсүх, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор Ч.Эрдэнэчимэг, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Үнэлгээ, мониторингийн газрын референт А.Амармэнд нар байлцав.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын биеэ даасан хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Баярбаатар:** “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Хэрлэн, Ж.Батсуурь нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 22 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.БАЯРБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
14 цаг 08 минут

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

01 сарын 21-ний өдрийн ээлжит хурал ирц хүрсэн байна.

Баярмагнай овогтой Баярбаатар ирсэн байна, Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна, Ч.Лодойсамбуу гишүүн гадаадад томилолттой, Д.Жаргалсайхан гишүүн гадаадад томилолттой.

Ингээд ирц хүрсэн учраас өнөөдрийн Байнгын хорооны хурлыг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцэх.

Хоёрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Авах арга хэмжээний тухай буюу өнгөрсөн хугацаанд Х.Баасанжаргал гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсож, тогтоол батална гэсэн ийм хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё.

#### Нэг.Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцэх

Нэг.Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсэг. Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Д.Баатарсайхан Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Б.Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ш.Батсүх Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор, Д.Дуламсүрэн Ёс зүйн хорооны орон

тооны бус гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн Албаны дарга, эрхэлсэн комиссар, Ч.Эрдэнэчимэг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор, Н.Ганбаатар Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга, Ц.Заяхүү Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга гэсэн ажлын хэсэг орж ирсэн байна.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос ирүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын 2024 оны тайлан болон хөндлөнгийн үнэлгээний тайланг Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.1.14-т Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг жил бүр хэлэлцэнэ гэж заасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.6-д энэ хуулийн 115.2-т заасан Засгийн газрын тайлан, илтгэлийг Ерөнхий сайд, холбогдох байгууллагын тайлан, илтгэл мэдээллийг тухайн байгууллагын дарга, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тайлан, илтгэл, мэдээлэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, үг хэлж болно гэсэн байгаа.

Ингээд танилцуулгыг Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс танилцуулна. Ц.Амартөгс даргын микрофон 6 номер.

**Ц.Амартөгс:** Та бүхний энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны 2024 оны тайланг бэлтгэн системийн үнэлгээний аргачлалын дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэн Их Хурлын 2024 оны 36 дугаар тогтоолоор баталсан цаглаварт заасан хугацаанд хүргүүлсэн.

Ийм учраас бид товч тайланг тоймлон танилцуулъя.

Нэг.Төрийн албанд ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор батлагдсан анхдагч хууль, холбогдох бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр төлөвлөгөөнд ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хариуцлагын механизмыг бүрдүүлэх заалтуудыг тусгасан.

Хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхэлсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан дүрэм, журам, холбогдох шийдвэрийг Улсын Их Хурал, Байнгын хороо, Ёс зүйн хорооноос гаргасан.

Эдгээр шийдвэрүүдийн хүрээнд Ёс зүйн хороо, дэд хороо байгуулах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, зарим тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн агуулгаар шийдвэрүүд гарсан байна.

Хоёр.Төрийн албаны ёс зүйн тогтолцоог бүрдүүлж байна.

Ёс зүйн хорооны хувьд 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн, орон тооны бус 4 гишүүнтэй ажиллаж байна.

Ёс зүйн хорооны гишүүний ажиллах нөхцөл, баталгааг энэ хууль, Байнгын хорооны баталсан Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм, Улсын Их Хурлын 2024 оны 55 дугаар тогтоолоор баталсан Төрийн өндөр албан тушаалын ангилал, зэрэглэлд тооцсон тогтоол, Улсын Их Хурлын 2019 он ны 63 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан цалингийн итгэлцүүрийн хүрээнд зохицуулж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.7 дахь заалтыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг батлан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлж байна.

Уг журамд төрийн албан хаагч нь гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл эдэлж байгаагүй, сахилгын болон ёс зүйн шийтгэл хүлээгээгүй, шударга, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн байх гэдэг нийтлэг шаардлагыг тавьсан.

2024 оны байдлаар нийт 2281 Ёс зүйн дэд хороо байгуулагдаж, нийт 9855 төрийн албан хаагч Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ёс зүйн дэд хорооны 79.3 хувь нь орон нутагт, 20.7 хувь нь нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа.



Ёс зүйн дэд хорооны гишүүдийн 9.3 хувь нь удирдах албан тушаалтан, 75.2 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан, 15.5 хувь нь туслах албан тушаалтан байна.

Сангийн яамны төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс харахад Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд байгаа нийт албан хаагчдад 65 байгууллага 192.6 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

Энэхүү хууль тогтоомж, холбогдох бусад эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, сурталчлан таниулах, сургалт, сурталчилгааны хүрээг өргөжүүлэх шаардлага их байгаа нь харагдлаа.

Түүнчлэн дэд хороодын гишүүний бие дааж шийдвэр гаргах хууль хэрэглээний практикт суралцах боломжийг бүрдүүлж өгөхөд илүү анхаарч ажиллах нь зүйтэй байгаа гэж дүгнэж байгаа.

Төрийн албан дахь ёс зүйн тогтолцооны харьцуулсан судалгаа хийж үзэхэд Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Герман Улс, Япон Улс зэрэг 4 улс нь төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг хуульчилсан бол Австрали, Канад, Франц, Сингапур, Турк зэрэг улс төрийн албан хаагчийн ёс зүйг тусгайлсан дүрэм, журмаар зохицуулдаг байна. Хууль, дүрэм, журамдаа ёс зүйн асуудлыг хамрах хүрээг институцийн эрх зүйн чадамжийг бие даасан үйл ажиллагааг тусгадаг ийм нийтлэг жишиг байдаг байна.

Монгол Улсын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд төрийн байгууллага албан тушаалтны хамрах хүрээ, ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүйн болон салбарын онцлог, асуудлуудын зохицуулах уялдаа нийцлийг хангах хэрэгцээ шаардлага үүсэж байгаа.

Түүнчлэн зарим бусад улсын жишгээр нийгмийн өмнө тулгамдаж буй ёс зүйн асуудлыг авч үзэж, нийгэм, хувь хүний үнэт зүйл, ёс суртахуунд чиглэсэн зөвлөмж, чиглэл боловсруулах үүрэг бүхий өргөн хүрээнд ажиллах эсэх асуудлыг харьцуулан судалж үзэх шаардлагатай гэж бид дүгнэж байгаа.

Гурав.Төрийн албан хаагчдын ёс зүйн төлөв байдлын тойм.

Монгол Улсад 4239 төрийн байгууллага, 226 мянга 496 төрийн албан хаагч болон энэхүү хуульд заасан албан тушаал эрхэлж буй 500 гаруй албан тушаалтан хамаарагдаж байгаа.

2024 онд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотойгоор 595 гомдол мэдээлэл хүлээж авснаас зөрчил хэмээн тогтоогдсон 322, тогтоогдоогүй 228 байна.

Эдгээр гомдлын 47.5 хувь нь иргэнээс төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд, 40.7 хувь нь төрийн албан хаагчдаас төрийн албан хаагчийн үйл

ажиллагаанд, 11.9 хувь нь байгууллагынхаа дотоод хяналт шалгалтаар гаргасан гомдол мэдээллийг эзэлж байгаа юм.

Нийт ёс зүйн гомдол мэдээллийг холбогдогч төрийн албан хаагчийн албан тушаалын ангиллаар нь ялгаж авч үзвэл 230 нь төрийн захиргааны, 236 нь төрийн үйлчилгээний, 50 нь улс төрийн, 60 нь төрийн тусгай албаны албан тушаал эрхэлдэг албан хаагчид байна.

Ёс зүйн гомдол мэдээлэлд дурдагдсан энэхүү 600 албан хаагчийн 333 нь эмэгтэй, 267 нь эрэгтэй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил хэмээн тогтоогдож дүгнэлт гаргасан 322 дүгнэлтээс 87.3 хувьд нь томилох эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэсэн байна. Үүнээс 7.6 хувь нь удирдах албан тушаалтанд, 76.6 хувь нь гүйцэтгэх, 15.8 хувь нь туслах албан тушаалтанд хариуцлага ногдуулсан байна гэж үзнэ.

Гомдол мэдээлэлд холбогдсон улс төрийн албан тушаалтны 18 хувь, Төрийн захиргааны албан тушаалтны 40 хувь, Төрийн захиргааны албан тушаалтны 66.6 хувь, төрийн үйлчилгээний албан тушаалтны 72.4 хувь нь зөрчил хэмээн тогтоогдож ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн гэсэн тоо гарсан.

Ёс зүйн зөрчил гаргаснаа хүлээн зөвшөөрч сайн дураараа ёс зүйн хариуцлага хүлээсэн тохиолдолд нийт зөрчлийн 12.7 хувь буюу 40-ийн гомдол байна.

Эдгээр нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эхний үр дүнг илтгэж байгаа болно.

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, бид ёс зүйн сургалтын агуулга, чиглэлийг тодорхойлсон.

2024 онд танхимаар 476 төрийн байгууллагын 26.8 мянга, Төрийн албаны зөвлөлийн вебинар цахим системээр 49.4 мянган албан хаагчдад ёс зүйн хууль тогтоомжийн мэдээлэл өгч, дүрэм, журмыг хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулсан.

Энэ нь нийт төрийн албан аагчдын 33.6 хувь болж байна.

2024 оны 11 дүгээр сарыг бид “Ёс зүйтэй” нөлөөллийн аян болгож зарласан. Ингэснээр 235 нь төрийн байгууллагын 2260 гаруй төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэнд, дижитал ёс зүй зэрэг шинэ чиг хандлагын талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.

Энэхүү сарын аян нь жил бүр уламжлал болгож болохуйц онцлог ажил болсон гэж дүгнэж болно.

Ёс зүйн хороо бодлого шийдвэрийг боловсруулахдаа төрийн албан хаагчид, олон нийтийн оролцоог хангаж ажиллаж байна. Тухайлбал, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулах явцад цахим танхим хосолсон 7 удаагийн хэлэлцүүлгээр 95 байгууллагын 1009 саналыг авч тусгасан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн багц цагийн сургалтын агуулгыг хоёр удаагийн танхимын хэлэлцүүлэгт 144 байгууллагын болон цахимын санал авч тусган баталсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт нь удирдах, гүйцэтгэх албан хаагчийн болон ёс зүйн дэд хорооны гишүүдийн сургагч багшийн гэсэн ялгаатай агуулгын хүрээнд шаталсан сургалтын хэлбэрээр зохион байгуулагдахаар төлөвлөж байгаа байгууллага салбарын онцлогт багтаан багц цагийн хөтөлбөрийг зохион байгуулна.

Ингэснээр төрийн албан хаагчдын ёс зүйн сургалтын хэрэгцээнд тулгуурласан үр дүнтэй, мөн сургалтын хүртээмж нэмэгдэнэ гэж харж байна.

Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороод ч гэсэн өөрсдөө бас энэ хуулийг хэрэгжүүлэх талаар идэвх санаачилгатай ажиллаж байгааг энд бас дурдах нь зүйтэй болов уу.

Ийм учраас бид 2025 онд дэд хороодын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, судалгаа болон эрсдэлийн үнэлгээг зарим томоохон салбар байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Тав.Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим системийн модулыг бид хөгжүүллээ.

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын систем нь Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системийн суурь өгөгдөлд суурилан төрийн байгууллага, төрийн албан хаагчийн бүртгэл дээр тулгуурлаж байгаа. Энэ нь мэдээллийн давхардал, зөрүү гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хатуу болон зөөлөн дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх сайн талтай гэж бид үзэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системийг 2024 оны 12 сарын 02-ноос туршилтын байдлаар нэвтрүүлэн энэ оны эхнээс бүрэн хэмжээнд ашиглахаар эхлүүлсэн.

Мэдээллийн нэгдсэн сан үүссэнээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, гомдол мэдээллийн нэгдсэн тайлан цахимаар шууд гарах, улмаар байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт шийдвэр гаргалтад ашиглах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа.

2025 онд Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөө, тайлан, ёс зүйн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн явцын дэлгэрэнгүй мэдээллийн нэгдсэн санг үүсгээд, иргэн өөрөө гомдол, мэдээллээ хэрхэн яаж шийдвэрлэгдэж байгаатай танилцах боломжийг хөгжүүлнэ гэж харж байна.

Зургаа.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, судалгаа эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсрууллаа.

2024 оны 11 дүгээр сард Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн төлөв байдал, шалтгаан, нөлөөлөх зүйлс сэдэвт туршилтын судалгааг эрдэмтэн судлаачдын багтай хамтран хийлээ.

Ингэснээр судалгааны арга зүй, удирдамж, асуумжийг боловсруулсан. Энэ нь төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл, шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох зорилготой.

2025 онд энэхүү судалгааг улсын хэмжээнд зохион байгуулна.

Ёс зүйн зөрчлийн эрсдэлийг үнэлэх нь тухайн байгууллага, салбар, эсвэл хувь хүн ёс, суртахууны хэм хэмжээ, ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэж харж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энэхүү тоймлон дурдсан 6 хэсэг үйл ажиллагаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж бид цаашдынхаа үйл ажиллагааг төлөвлөж байгаа болно.

Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, хуулиар тогтоосон нийтлэг үүрэг хориглох зүйлийг хэлбэрэлтгүй сахин мөрдүүлэхэд хууль тогтоомжийн хоорондын уялдааг сайжруулах шаардлага хэрэгцээ байгаа боловч хүнлэг энэрэнгүй, шударга, хариуцлагатай, хамтарч байх зарчимд суурилсан харилцаа хандлага, зан үйлийн өөрчлөлтийг хийхэд удирдах ажилтны албан тушаалтны манлайлал ёс зүйн үлгэрлэл чухал нөлөөтэй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар, байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад тулгуурлан тодорхойлж, жил бүр төлөвлөгөө, төсөвтөө тусган санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулан хэрэгжүүлэх, үр дүнгээ тооцож ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

Төрийн албаны ёс зүйн тогтолцоог шийдвэр гаргалт, ажиллах орчин, хүний нөөц, цалин хөлсний баталгаа, санхүүгийн эх үүсвэрийг хамруулсан өргөн хүрээнд бэхжүүлэх нь чухал гэж үзэж байна.

Ингэснээр төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдан, төрийн албанд шударга, хариуцлагатай байдал дээшилж, эерэг үр дагавар, нийгмийн нөлөөллүүд бий болно гэж үзэж байгаа.

Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхыг дээшлүүлэхэд хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Хамтын ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бид 7 дугаар сард 13 олон улсын байгууллага, 8 гадаадын Элчин сайдын яамдын төлөөллийг оролцуулсан уулзалт, танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Улмаар 4 улсын Элчин сайд, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчтэй тусгайлан уулзаж хамтын ажиллагааны санал солилцоод байгаа болно.

Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургах, хөгжүүлэх нь зайлшгүй. Үүнд, төрийн албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай суурь чадамжийг эзэмшүүлэх, шинэ мэдлэг, дадлага, хандлагыг төлөвшүүлэхэд үр дүнтэй үйл ажиллагаанд чиглэсэн сургалт, хөгжлийн шинэчлэл шаардлагатай байгаа.

Энэхүү шинэчлэлийг төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээ үйл ажиллагааг дэмжихэд ёс зүйн индекс, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах зэрэг шинэлэг арга хэрэгслийг нэвтрүүлнэ.

Төрийн албан хаагч, иргэнд үйлчлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хариуцлагатай, ил тод, ажиллах нөхцөлийг бататган, салбар хоорондын уялдааг хангах бодлогоо тууштай хэрэгжүүлнэ.

Ёс зүйн хороо хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээндээ 2025-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан.

Энэ хүрээнд 2025 онд төрийн албан хаагчид, ялангуяа удирдах албан тушаалтны ёс зүйн манлайллын нэмэгдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, соён, гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх, судалгаанд суурилсан бодлого, чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх зорилтуудыг тавиад байна.

Үнэт зүйл, харилцааны зарчимд суурилан хэрэгжих энэхүү ёс зүйн хуулийн хэрэгжилтийг өргөжүүлснээр зөв зүйтэй хандлага, төлөвшил бүхий хариуцлагатай төрийн албан хаагч, байгууллагын тоо нэмэгдэнэ гэж үзэж байна.

Ингэснээр мөн олон нийтийн хүлээлтэд нийцсэн үйл ажиллагаа явуулах ийм боломж бүрдэнэ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн төлөв байдлын эхний тайланг танилцууллаа.

Та бүхэнд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс дарга танд баярлалаа.

Тайлан, танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

3 гишүүн. Зөв үү. Тасаллаа. Г.Очирбат гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүн асуулт асууна.

**А.Ариунзаяа:** Ёс зүйн хорооны тайланг сонсоод ер нь зөвшөөрч өгөгдсөн боломжит нөөцдөө дажгүй сайн ажилласан гэж үзэж байгаа.

Учир нь бид оногдсон орон тоонд нь гүйцэд ажиллуулж чадахгүй. Энэ жилийн хувьд ч гэсэн төсөв батлахад байх ёстой орон тоонд нь бас л орон тоог нь нэмж чадаагүй. Хэвээрээ. Одоо яг энэ байгаа байдлаар нь ажиллуулах ийм Төсвийн хуулийг баталчихсан байгаа учраас байгаа нөөц бололцоондоо багтаж бас ажлаа хийх ийм нөхцөл шаардлага үүсэж байгаа учраас боломждоо нийцсэн дажгүй сайн ажлуудаа хийсэн гэж үзэж байгаа.

Цаашдаа ч гэсэн бид дөнгөж яах вэ 53, 54 хувь, байгууллагуудын 54 хувь нь энэ Ёс зүйн хороогоо байгуулсан байгаа нь цаашид маш их энэ ажлын хэрэгцээ шаардлага үүссэн байгаа юм байна гэдэг нь харагдаж байна.

Зүгээр би яагаад үг хэлэх гээд байна вэ гэхээр энэ ёс зүйн асуудал маань өөрөө бас яг шууд хуулиар барьж аваад л юу гэдэг юм хариуцлага тооцоод ч гэдэг юм уу, шууд барьцтай асуудал бас биш учраас энэ шинэлэг ийм ойлголт болж орж ирж байгаа.

Тэгэхээр энэ ёс зүйг хэнээс нэхээд байгаа юм бэ гэхээр ер нь л төр өөрийнхөө үзүүлж байгаа үйлчилгээ, төр иргэний хооронд үүсэж байгаа энэ харилцаа нь дээр л өөрийнхөө үзүүлэх ёстой үйлчилгээгээ муу үзүүллээ, ёс зүйгээ авирлалаа гэдэг энэ иргэдийн гомдол дээр л ер нь суурилж гарч байгаа шүү дээ. Эсвэл ажилтан, албан хаагч хоорондоо, удирдах, удирдуулж байгаа хүн хоорондоо энэ харилцаан дээр үүсэж байгаа чи ёс зүйгүй авир гаргалаа гэдэг л ийм асуудал болов уу гэж би ойлгодог.

Тэгээд энэ ёс зүйгүй гэж гарч байгаа гомдлууд хаана гардаг вэ гэхээр нэгдүгээрт яах вэ хамгийн их төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаа газар. Нэн ялангуяа миний ажиллаж байсан салбар буюу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар гэдэг ч юм уу. Тийм ээ. Халамжийн ажилтнууд гэдэг ч юм уу, яг тухайн маш их ачаалалтай ажилладаг хүмүүс дээр энэ бухимдал, ёс зүйгүй энэ харилцаа үүслээ гэж үздэг.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн бид яах вэ, Төрийн албаны зөвлөл хамгийн олон энэ ёс зүйн гомдол ирээд байгаа ажлын байрууд дээр ажлын ачааллын ажлын байрны энэ зураг авалтыг бас хийж үзэх хэрэгтэй юм шүү гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Яагаад гэвэл яахын аргагүй үнэхээрийн ачаалал өндөртэй газар хүн бухимдаж болно, сэтгэл зүйн дарамтад орж болно. Тийм ээ. Энэ дээр бас их ёс зүйгээ авирлалаа гэсэн ийм гомдлууд ирэх тохиолдлууд маш их байдаг учраас үүнийг нэг талдаа мэргэжилтнийг сануулах арга хэмжээ авах солих, сургах биш харин энэ ажлын ачааллыг нь бууруулах талд бид бас анхаарч ажиллах ёстой юм гэдэг ийм санал юм уу даа. Санал хэлж байна.

**Б.Баярбаатар:** А.Ариунзаяа гишүүн санал хэллээ. Бадарчийн Хэрлэн гишүүн

**Б.Хэрлэн:** Тэгэхээр бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Надад хоёр асуулт байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийнхаа 19 дүгээр зүйлд Ёс зүйн хороо нь үйл ажиллагааныхаа тайланг Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд танилцуулах ийм хуулийн зохицуулалттай.

Тэгэхээр өнөөдөр бид үйл ажиллагааны тайлан хэлэлцэж байна уу, эсвэл ёс зүйн зөрчлийн төлөв байдлын тухай судалгааны тайлан бид хэлэлцэж байгаа юу? Хэрвээ үйл ажиллагааны тайлан юм бол Ёс зүйн хорооноос танай байгууллагаас яг юу хийв? Энэ дотроо өнгөрсөн хугацаанд ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй, ямар төсөв санхүүгээр ямар ажлыг хийсэн юм бэ гэдэг тухай мэдээлэл байх ёстой байх. Энэ тухай мэдээлэл энд алга.

Хоёрдугаарт, одоо бид Ёс зүйн хорооны тайлангуудыг ерөнхийдөө үйл ажиллагааны тайлангуудыг бас өмнө нь сонсож байсан. Ялангуяа гомдлын тухай бид бас ярьж байсан. Одоо энд 322 гомдол ирсэн тухай, тэрийг шийдвэрлэсэн тухай. 322 гомдлыг буруутай гээд үүнийг шийдвэрлэсэн тухай энд статистик мэдээ хэлж байна.

Тэгэхээр бид түрүүчийн хэлэлцүүлгийн явцад энэ гомдлуудад дүн шинжилгээ танайх хийв үү? Ёс зүйн ямар ерөнхий шаардлага, хэм хэмжээ голдуу алдагдаад байгаа юм гэдэг дээр дүн шинжилгээ хийв үү гэж асуусан. Тэр үед бол хариулт байгаагүй.



Яагаад үүнийг асууж байгаа юм бэ гэхээр өнөөдөр яг төрийн албанд яг ямар ёс зүйн яг ямар хэм хэмжээ зарчим нь алдагдаад байгаа юм үүнийг энэ юунаас болоод энэ зөрчил энэ гомдол гараад байгаа юм. Цаашдаа танай байгууллага голлож сургалт явуулна л гэж байна.

Тэгэхээр хэрвээ соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах гэж байгаа юм бол дараа жилийн чинь төлөвлөгөөний гол суурь нь тэр болох ёстой л байсан байхгүй юу. Тэр утгаараа асуугаад нэхээд байсан. Тэгээд өнөөдөр энэ ёс зүйн гомдлын талаарх, ёс зүйн, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн төлөв байдлын тайлан дотор яг тэр өмнө асууж байсан асуултын хариулт бас л байхгүй л байна л даа.

Тэгэхээр надад энэ хоёр зүйлийг хариулаад өгөхгүй юу? Энэ үйл ажиллагааны тайлан юм уу, хэлэлцэх ёстой юм уу, бид эсвэл ёс зүйн зөрчлийн нэгдсэн тайланг, нэгдсэн төлөв байдлын тухай энэ дүнг бид хэлэлцэх ёстой юм уу? Хэрвээ үйл ажиллагааны тайлан бол санхүүгийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэл бас энэ дотор байх ёстой юу, үгүй юу?

Хоёрдугаарт нь, нөгөө нэг гомдолтой хийсэн дүн шинжилгээ чинь байх ёстой байсан уу, үгүй юу? Энэ хоёр асуултад хариулаад өгөх үү?

**Б.Баярбаатар:** Ц.Амартөгс дарга. 6 номерын микрофон.

**Ц.Амартөгс:** Б.Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 19.3-д үйл ажиллагааны тайланг танилцуулахаар байгаа. Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр төрийн албан хаагчийн ёс зүйн төлөв байдлын нэгдсэн дүнг танилцуулахаар заачихсан байгаа.

Тийм учраас бид энэ тайланг аль аль агуулгыг нь багтаасан байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, зөрчлийн нэгдсэн дүнгийн тайлан гэж ингэж агуулгаар нь багтаасан байгаа.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн бүхий л үйл ажиллагаагаа энд тусгаж оруулсан.

Ялангуяа Ёс зүйн хороо өнгөрсөн хугацаанд 2024 оны 02 сарын 01-нээс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Ажлын алба буюу алба нь 24 орон тоотой байхаар батлагдаад 4 сараас эхэлж ажлын албаны эхний албан хаагчдыг авч эхэлсэн.

Одоогоор 18 албан хаагчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулаад авсан ийм нөхцөл байдалтай байна.



Мөн төрийн албан хаагчдыг авч чадахгүй байсан нөхцөл байдал нь үйл ажиллагаа эрхлэх байрны асуудлаа шийдэж чадахгүй байсан учраас аль болох багтаамжийнхаа хүрээнд үе шаттайгаар авсан.

Мөн сүүлийн сарын хугацаанд бид тодорхой байрны нөхцөл бололцоо сайжирсан учраас төрийн албан хаагчдыг нэмэгдүүлж авсан гэж хэлж болно.

Төсвийн тухайд Төрийн албаны зөвлөлийн ерөнхийлөн захирагчийн төсөв дотор 1.1 тэрбум төгрөгөөр батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Үүнтэй холбоотойгоор бас нөгөө төрийн албан хаагчдыг бүрэн орон тоогоор нь авч ажиллуулаагүйтэй холбоотой цалин хөлсний хэмнэлт гарсан байгаа.

Нийт төсвийн зарлагын 94.5 хувийн ашиглалттай гэж хэлж болно. Бусад зардал дээр.

Бид судалгаа хийсэн. Зөрчлийн бүртгэлүүдээ гаргаад нийт ирж байгаа гомдлыг яг ямар байдлаар гаргаж байна вэ гэдэг дээр.

Тэгэхээр төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль дээр заасан зарчмыг нийтлэг хэм хэмжээ, шаардлага болгоод заачихсан. Нийтлэг үүрэг, хориглох зүйлээс бүрдэнэ гээд.

Нийтлэг үүрэг буюу 8.1 гэдэг хуулийн үндэслэлээр гаргаж байгаа гомдол нь 45 хувь. 8.2-ын үндэслэлээр гаргаж байгаа гомдол нь ойролцоогоор 20 хувьтай байгаа юм. Тэгээд бусад үндэслэлээр гэсэн ийм зүйлүүд байна.

314 зөрчилд бид хариуцлага тооцсон гэж. 314 зөрчилд хариуцлага тооцоход энэ маань 16.1 буюу ихэвчлэн уучлалт гуйх, сануулах гэсэн энэ санцруудыг хэрэглэж байгаа. Энэ маань өөрөө өөрийнхөө гэм бурууг хүлээн зөвшөөрөх энэ хандлага руу явж байна гэсэн ийм байдлаар харагдаж байгаа.

Мөн хариуцлага сайн дураар хүлээсэн 40 тохиолдол байгаа. Энэ 40 тохиолдлын 13 тохиолдол нь зөрчил гаргаснаа хүлээгээд өөрөө өөрийнхөө санаачилгаар албанаасаа чөлөөлөгдсөн гэдэг энэ мэдээлэл гарч байгаа юм.

Тэгэхээр гомдол маань юун дээр үүсээд байна вэ гэхээр хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулахдаа иргэний асуудалд анхааралтай хандах ёстой гэсэн суурь нийтлэг үүрэг болгож заасан энэ асуудал дээр илүү төвлөрч гомдол гарч байна.

Нөгөө талаараа янз бүрийн үг хэрэглэх, доромжлох. Тийм ээ. Доромжилсон үг хэллэг хэлэх гэсэн энэ 8.1.3 гэдэг энэ зүйл.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Тодруулах уу? Б.Хэрлэн гишүүн тодруулчих.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр танай байгууллагын хувьд баримтлах гол хууль чинь болоод ирэхээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болж таарах байх.

Тэгэхээр тэр хуульд заасны дагуу та нар үйл ажиллагааныхаа тайланг Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороогоор хэлэлцүүлнэ гэсэн. Үүнийгээ бариад явах байсан болов уу гэж би нэгдүгээрт бодож байна.

Миний асуултууд ер нь их олон байгаа л даа.

Тэгэхээр энэ дээр ингэсэн байна л даа. Ер нь ёс зүйн зөрчлийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлээ гэсэн байгаа юм. Тэгснээ дараа нь салбарын хэмжээний бодлого, төлөвлөлтөд ёс зүйн эрсдэлийг бууруулах талаар, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх талаар салбарын бодлогуудад тусгалаа гээд тайлангийн чинь 19 дээр 2 пунктээр үйл ажиллагааныхаа тайландаа биччих л дээ. Үүнийг жаахан тодруулаад. Яг ямар бодлого, ямар санаануудыг тэнд тусгаад оруулчихсан юм бэ гэдгийг тодорхой хэлээд өгөх үү.

**Б.Баярбаатар:** Ц.Амартөгс дарга хариулъя.

**Ц.Амартөгс:** Өмнө дурдсан. 02 сарын 01-нээс үйл ажиллагаагаа явуулсан гээд.

Тэгэхээр энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийтлэг зөвхөн энэ хуулийг мэдэж байхаас гадна бүх салбарын өдөр тутмын үйл ажиллагааны үндэслэл болдог хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болон төсвийн төлөлтөд энэ заавал зорилт, үйл ажиллагаанууд уялдаатай суух шаардлагатай болсон.

Тийм учраас бид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үндэслээд 2030 он хүртэл төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр буюу дунд хугацааны бодлогыг гаргаж ирсэн.

Энэ хүрээндээ шинээр байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт олон салбарын оролцоотойгоор томъёоллыг нь оруулаад салбар салбарт эрсдэл дээр суурилсан үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилгоор нийтлэг зорилтуудыг тусгаж өгсөн нь энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд бас.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Ц.Амартөгс дарга. 6 номер.

**Ц.Амартөгс:** Энэ зорилтуудыг хийж өгснөөр бусад салбарын үйл ажиллагаа харилцан зорилтуудынх нь түвшинд уялдаатай байдал бий болж байна гэж үзэж байгаа.

Мөн сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хийх үндсэн зорилтын нэг байгаа.

Тэгэхээр энэ зорилтын хүрээнд бид бусад салбарын явж байгаа төрийн албан хаагчдаа сургаж мэргэшүүлж байгаа үйл ажиллагааг бас уялдуулах тал дээр нэлээн ахиц гарсан гэж тодорхойлж байгаа.

Энэ нь маань өөрөө сургалтын агуулга, багц цагийн сэдвийг уян хатан тогтоож өгөөд, зайлшгүй эзэмших ёстой агуулгын хүрээг сэдэв сэдвээр нь, мөн төрийн албан хаагчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа онцлог онцлогоор нь хөтөлбөрт суулгаж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн нь энэ өөрөө бас манай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бодлогын уялдаа гэж харж байна.

**Б.Баярбаатар:** Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд хүргэе. Тэгээд богино хугацаанд олон ажлууд хийсэн байна. Тайлантай танилцлаа. Тайлантай холбогдуулаад гурван асуулт асууя.

Нэгдүгээрт, төрийн албан хаагчдын ангилал 58 мянга гаруй төрийн болон орон нутгийн өмчит компаниудын захирал удирдах ажилтнуудыг хамруулсан байгаа юм. Тэгээд энэ ямар үндэслэлтэй вэ?

Энэ чинь Компанийн тухай хуулиараа, зарим нэг хэсэг нь бизнесийн салбарын хүмүүс болоод явчихдаг. Энэ дээр нэг тодорхой хариулт авчихъя.

Мөн дээрээс нь хэрвээ энэ ангилалд хамруулж байгаа юм бол тэр гүйцэтгэх шатын бүх ажилтан албан хаагч дээр нь хамруулах байсан уу, үгүй юу? Энэ дээр тодорхой нэг хариулт авчихъя.

Хоёрт нь, тайлантай танилцахад нийт төрийн байгууллагын 53.8 хувьд нь Ёс зүйн дэд хороо байгуулагдсан байна. Үлдсэн 47 хувьд нь яагаад байгуулж чадахгүй байгаад байгаа вэ? Ямар асуудал тулгараад байна? Ямар шалтгаанаар байгуулагдахгүй байгаа юм? Энэ талаар бас тодорхой хариулт авчихъя.

Гуравт нь, тайланд Ёс зүйн дэд хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд бас тодорхой хэмжээний урамшуулал олгодог юм байна. Тэгээд энэ дэд хорооны бүх гишүүд энэ урамшууллаа авч чадаж байгаа юу? Хэдий хэмжээний урамшуулал олгож байгаа вэ? Ёс зүйн хорооны төсөв хүрэлцээтэй байж чадаж байгаа юу? Төрийн албаны төсөвтэй холилдоод байгаа тал байна уу, үгүй юу? Энэ талаар нэг тодорхой хариулт авчихъя. Тэгээд тодруулъя.

**Б.Баярбаатар:** Г.Очирбат гишүүн маш тодорхой асуулт асуулаа шүү. Ц.Амартөгс дарга тодорхой хариулаарай. 6 номер.

**Ц.Амартөгс:** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хамрах хүрээг төрийн албаны тухай хуульд заасан 4 ангиллаас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын удирдах албан тушаалтан байхаар заасан.

58 мянга гэдэг маань тэдгээрт хамаарч байгаа зүгээр албан хаагчдынх нь тоо болохоос биш яг энэ албан хаагчдыг удирдан ажиллаж байгаа удирдах албан тушаалтнууд нь л манай энэ Ёс зүйн хуулийн дагаж мөрдөх хэм хэмжээг мөрдөх үүрэгтэйгээр ажиллаж байгаа.

Зарим төрийн өмчит үйлдвэрийн газруудад нэгэнт ийм төрийн байгууллагуудын хууль гарсан учраас бид бас ийм жишгийг өөрийнхөө байгууллагын дотоод журам болон бусад хууль тогтоомждоо нийцүүлэн хэрэглэе гээд гэдэг ийм зөвлөгөө зөвлөмж авч ажиллаж байгаа.

Шууд төрийн албаны ангилалд тэр байгууллагын албан хаагчдыг оруулахгүй байгаа.

Дэд хороод байгуулагдсан 53.8 хувийн хувьд нэн тэргүүнд байгуулах шаардлагатай гэдэг юм уу, суурь ёс зүйн зөвлөлүүд ажиллаж байсан байгууллагууд эхлээд шилжилт хийх байдлаар байгуулсан.

Дараагийн асуудал нь босоо удирдлагатай буюу нөгөө дээрээсээ томилогддог байгууллагын албан хаагчид нь нэгж гэж үзээд бие дааж байгуулах уу, төв удирдлагадаа хамаарч дэд хороонд харьяалагдах уу гэдэг асуудлыг бид судалж үзээд үйл ажиллагаа явуулж байгаа байршилдаа хамаарсан дэд хороонд харьяалагдах юм байна гэдэг ийм зохицуулалтыг хийсэн учраас энэ тоо 53.8 гэдэгт нөлөөлж байгаа.

Үүний зэрэгцээ сумын түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын цөөн албан хаагчтай төрийн байгууллагуудын хувьд томилох эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийг хэрэгжүүлэх зохицуулалт бол үйлчилж болох юм байна заавал дэд хороо байгуулах шаардлагагүй юм гэдэг бас ийм тайлбар мэдээллийг бид гаргаж байгаа.

Яагаад гэхээр 10 болон түүнээс цөөн тохиолдолд 3-аас 7 гишүүнтэй ажиллана гэдэг бол бас нэгдүгээрт үйл ажиллагааныхаа зохион байгуулалтын хувьд ч гэсэн оновчтой биш байгаа учраас тухайн суманд зохион байгуулагдсан дэд хороонд харьяалагдаад, мөн удирдах албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлэх боломжтой гэж харж байгаа.

Дэд хороодын урамшууллын тухайд 3-аас 7 гишүүнтэйд дэд хороод маань хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр улиралд нэг удаа урамшууллийг авна. Нарийн бичгээр ажиллаж байгаа буюу нөгөө Байнгын үйл ажиллагааг хэрэглэж энэ сургалт үйл ажиллагааг төлөвлөж байгаа, хяналт бүртгэлийг хийж байгаа, нарийн бичгийн ажил хийж байгаа албан хаагч бол хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 50 хувиар тооцоод сар тутам энэ урамшууллийг олгох зохицуулалт хийгдсэн.

Санхүү, төсвийн төлөвлөөгүй байдалтай холбоотойгоор зарим байгууллагууд үүнийг өгөөгүй байна. Нөгөө талаас дэд хороогоо байгуулаад үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа гэдэг шалтгаанаар харилцан адилгүй өгч эхлээгүй байсан. Одоо бид төлөвлөгөөгөө гаргаад, үйл ажиллагаагаа эхлэх талаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмжүүд өгөөд дэд хороонд ажиллаж байгаа албан хаагчид маань ялангуяа үндсэн үйл ажиллагаагаа хийхэд нь дэмжлэг үзүүлэх ийм боломж нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж ажиллаж байна.

Бид бас энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувь болон улиралд нэг удаа олгох урамшууллийг тооцож үзэхдээ байгууллагын төсөвт ачаалал өгөхгүй байх тооцооллыг хийсэн. 3 буюу хамгийн цөөн албан хаагчтай дэд хороо гэхэд 9 сая. Жилд. 7 гишүүнтэй дэд хорооныхоо хувьд 19.7 сая хүртэл төгрөгийн урамшуулал олгох юм байна. Нэг байгууллага дээр гэдэг энэ тооцооллын хийсэн.

Ёс зүйн хорооны төсвийн тухайд одоогоор Төсвийн тухай хууль болон бусад хууль журмын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь Төрийн албаны зөвлөлийн дарга байгаа.

Төсвийн хувьд эхний жил байсан.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Тодруулах уу? Г.Очирбат гишүүн. Гүйцээгээд хариулчих. Ц.Амартөгс дарга. 6 номер.

**Ц.Амартөгс:** 1.1 тэрбум гэдэг маань үйл ажиллагаа эхлүүлэх түвшинд байсан. Одоо бид энэ сургалт болон бусад шинэчлэлийг хэрэгжүүлэх судалгаа улсын хэмжээний эрсдэлийн үнэлгээ болон индекс тооцоолох энэ арга зүйн аргачлалыг нэвтрүүлэх тохиолдолд магадгүй дараа дараа энэ жилүүдэд сууриа тавиад төсөв, үйл ажиллагаагаа зөвхөн Ёс зүйн хороо биш бусад дэд хороодтойгоо хамтарч хэрэгжүүлэх байдлаар аль болох үр дүнтэй төсвийн менежмент хийнэ гэж ингэж тооцож байгаа.

**Б.Баярбаатар:** Тодруулах уу? Болсон уу?

Гишүүд асуулт асууж хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байвал нэрс авъя.

Б.Хэрлэн гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн санал хэлнэ.

**А.Ариунзаяа:** Сая асуулт асуусан гишүүд дээрээ нэмээд дахиад хэлэхэд бид л өөрсдөө төсвийг нь бууруулчихсан.

Сая хэмнэлтийн тухай хуулийг төсөв дагуулаад хэдүүлээ бас баталчихсан шүү дээ. Тэгээд тэнд юу гэж орсон бэ гэхээр яг ажлынхаа хажуугаар үндсэн

цалингаа аваад хийж байгаа хүмүүс ямар нэгэн хороонд орох юм бол үндсэн цалингаа л авна. Нэмэлт ямар нэгэн урамшуулал авахгүй гээд заагаад өгчихсөн.

Тэгэхээр үүндээ илүү л үүрэг хүлээж байгаа болохоос биш илүү цалин урамшуулал аваад байгаа асуудал огт биш ээ гэж.

Ирсэн нийт гомдлуудыг аваад үзэх юм бол 47 хувь нь иргэнээс ирсэн, 40 хувь нь төрийн албан хаагчаас, төрийн албан хаагчийнхаа талаар гомдол ирсэн.

Дотоод хяналтын байгууллагаас нь хэн нэгэн ажилтнаа чи ёс зүйгүй авир гаргаж байна шүү гэдэг энэ гомдлыг 12 хувь нь гаргасан юм байна гэсэн ийм дүгнэлт байгаа.

Тэгээд дахиад тодруулж хэлэхэд яг энэ ёс зүйгүй үйлдэл гараад байна, иргэнээс энэ гомдол ирээд байгаа энэ ажил дээр нь тухайн албан хаагчдынх нь ажлын байрны зураг авалт яагаад ийм нөхцөл байдал үүсээд байна вэ гэдгийг та хэд маань бас анхаараарай. Яагаад гэвэл цаашид одоо энэ асуудал дээр дүн шинжилгээ хийх, судалгаа хийх тал дээр нь ороогүй байгаа учраас би үүнийг бас хэлээд байгаа юм.

Ер нь энэ бухимдал, ёс зүйгүй үйлдэл хаана гардаг вэ гэхээр үл ойлголцол болоод, ажлын их ачаалал болоод, нерв стресс ихтэй газар л энэ чинь гардаг шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээрээ л аль болох төрийн алба маань өөрөө ёс зүйтэй, зөв зохистой, тайван. Тийм ээ. Байхын тулд ажлын ачаалал болон стресс үүсэж байгаа орчныг нь бид өөрсдөө яг уг углуургаар нь байхгүй болгож байж сая яг энэ Төрийн албаны хуулийнхаа дагуу хийх боломжтой, ажлаа хийх боломжтой болно. Тэгээд энэ гарсан гомдлынх нь 79 хувь нь төрийн албаны хуулийн энэ 8.1-тэй холбоотой гарсан гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь өөрөө төрийн албан хаагчид тавигдах нийтлэг үүрэг буюу иргэний хүсэлтэд анхааралтай хандаж хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх ийм гомдлоор байгаа юм. Тийм ээ. Нийт гомдлынх нь 79 хувь нь. Тэгээд бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх. Хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг хэллэг хэрэглэхгүй байх гэдэг энэ заалтуудыг зөрчсөн байна гэж орж байгаа ёс зүйгүй үйлдлүүд нь дийлэнх олонх нь байна гэдэг чинь өөрөө л ердөөсөө л энэ стрессийн үеийн чи ямар балай, ийм бэ, тийм бэ гэж л хэлж байгааг. Би чамайг ёстой Ёс зүйн хороонд өгнө өө гэдэг л ийм харилцаа шүү дээ.

Тэгэхээр яагаад ийм асуудлууд үүсээд байна вэ гэдэг дээр л бид зүгээр нэг хариуцлага тооцож тухайн хүнийг дуугүй байлгах биш харин тэр нөхцөлийг бий болгоод байгаа, энэ ажлын стрессийг бий болгоод байгаа орчныг байхгүй

болгох, ажлын байрны зохистой орчныг бий болгох тал дээр л анхаарах ёстой юм гэдгийг бас дахиж захиж хэлье. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Санал хэллээ. Д.Энхтуяа гишүүн.

**Д.Энхтуяа:** Өнөөдрийн хэлэлцэж байгаа Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны ажлын тайлан дээр надад хэлэх асуудал, асуух асуулт алга.

Тэгээд та бүхэнтэйгээ бас энэ Ёс зүйн хорооны гишүүний хувьд ажлын хэсэг гээд нэлээн хуралддаг учраас Та бүхний хувьд Монгол Улсад төрийн албанд хэрэгжиж байгаа энэ ёс зүйн дүрэм, журам энэ бүгдийг л их дүрмийн хэмжээнд, журмын хэмжээнд сайжруулах гээд ажиллаж байгаад миний хувьд Та бүхэнд талархаж ханддаг ийм гишүүн байна.

Гол нь юу хэлэх гээд байна гэвэл өнөөдөр бид, сая ч гэсэн бас ярьж байна.

Ер нь Ёс зүй гэдэг чинь юу гэдэг юм, барьцгүй. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр бид соён гэгээрүүлэх, төрийн албаны ёс зүйн хувьд, сэтгэлгээний хувьд өөрчлөлт хийх ёстой гэж би боддог байхгүй юу. Магадгүй Монгол хүмүүс чинь Буддын шашинтай болохоор шашинтай нь холбодог юм уу.

Ер нь төрийн албаны ёс зүй гэдэг дээр ийм сэтгэлгээний өөрчлөлт хийх ёстой.

Дээрээс нь Монгол хүний төрийн албанд ажиллах үнэт зүйл юу юм бэ гэдгийг маш тод томруунаар гаргаж ирж, үүнийг хэвшүүлэх сэтгэлгээний өөрчлөлт хийх ёстой л гэж ингэж би боддог юм.

Яг дүрэм журам цаасан дээр буусан юман дээр манай төрийн албаныхан хангалттай сайн ажиллаж байгаа. Харамсалтай нь өнөөдөр төрийн өндөр дээд алба албан тушаал хашиж байгаа хүмүүсээс ёс зүйн алдаа гаргаад өнөөдөр өнгөрсөн хугацаанд ард иргэдээсээ уучлалт гуйгаад, хариуцлага хүлээдэггүй юмаа гэхэд уучлалт гуйгаад олон түмэндээ хандсан ийм тохиолдол бараг байхгүй л байгаа шүү дээ.

Тэгэхээр бид төрийн албаны ёс зүйн алдаа гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэж байна гээд л ерөнхийдөө л хэдэн багш, эмч нар луугаа л ханддаг. Тэр багш, эмч нарын хариуцлага хүлээх санкц нь маш тодорхой байгаа. Тэр хүмүүс л хариуцлага хүлээдэг.

Гэтэл өнөөдөр нөгөө төрийн албанд ажиллаж байгаа, төрийн албаны өндөр дээд албан тушаалтнууд, бид энэ Улсын Их Хурлын танхимд сууж байгаа гишүүд ч гэсэн өөрсдөөсөө эхлэх ёстой.



Ямар нэгэн, ядаж ёс зүйн алдаа гаргасан бол уучлалт гуйчихдаг, бүтэн нүүрээрээ харж байгаа камер луу нүдээрээ харж байгаад уучлалт гуйчихдаг энэ л сэтгэлгээний өөрчлөлт, энэ үнэт зүйлийг л бий болгох хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр энэ дээр та бүхэн бас энэ соён гэгээрүүлэх, сурталчлан таниулах, хэвлэл мэдээлэлтэйгээ харьцаж ард иргэддээ таниулах ажлаа 2025 онд арай түлхүү хийх юм бол энэ илүү үр дүнтэй болох болов уу гэж ингэж би харж байгаа юм. Ингээд та бүхэнд амжилт хүсье.

**Б.Баярбаатар:** Д.Энхтуяа гишүүн чухал санал хэллээ. Бадарчийн Хэрлэн гишүүн санал хэлнэ.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр ер нь бидний асууж байгаа асуулт, хэлж байгаа үг бол бүгдээрээ л Монгол Улсын төрийн албаны ёс зүйг сайжруулахын төлөө та бүхний үйл ажиллагаанд хэрэг болох санаануудыг хэлээд байгаа гэдэг талаас нь харж хүлээж аваарай.

Тэгэхээр төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулиа уншихаар ерөнхийдөө танай байгууллагын үйл ажиллагаа гарсан ёс зүйн гомдлуудыг бүртгэж аваад л тэгээд хэрхэн хянаж шийдвэрлэж, хариуцлага тооцсон юм. Тэрийг нь бүртгэлжүүлээд л цахимжуулаад л, тэгээд л олон нийтэд мэдээлээд л явах жишээтэй иймэрхүү ажлуудыг хийхээрээр хуульд тусгаад ороод ирчихсэн байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээрээс би юу хэлэх гээд байна вэ гэхээр, бид ерөөсөө ёс зүйтэй, ёс зүйг эрхэмлэсэн төрийн албыг бий болгоё гэх юм бол алдаа бүрийнх нь хойноос хөөцөлдөөд, бүртгээд, тэгээд тэрийг нь бүртгэлд оруулаад, тэгээд цааш нь уламжилж мэдэгдээд явдаг ийм арга биш. Түүний оронд арай өөрөөр, сайн руу тэмүүлэх, улам сайн сайхан болох тэр сэтгэлийг хүмүүст бий болгох, одоо нөгөө үйл ажиллагааныхаа чиглэлийг тэс өөр талаас нь харж хийвэл бид яасан юм бэ л гэж би танай хуулийг хараад, тэгээд явуулж байгаа үйл ажиллагаануудаас нь хараад бодоод л суугаад байна л даа.

Тэгэхээр бид ярьдаг шүү дээ. Хагархай цонхны онол гээд л ярьдаг. Хэрвээ цонх хагархай байх юм бол тийшээ хүн болгон л чулуу шиддэг. Хэрвээ төрийн албан хаагч муу байна, ёс зүйн алдаа зөрчил гаргаад байна гээд л цахимд бүртгээд л, тэгээд олонд таниулаад л байх юм бол нэлэнхийдээ харлаад л. Ёстой нөгөө туулайн чинээ хараар уулын чинээ цагааныг харлуулаад л яваад өгчихнө. Тийм биз.

Тэгэхээр түүний оронд бид сайн руу тэмүүлэх, улам сайн болох тийм зөв үлгэр дуурайлыг авдаг байх, зөв юманд тэмүүлдэг байх ийм сэтгэлийг хүнд бий болгох арай өөр арга замаар ажиллахаар та бүхэн ирэх жилийнхээ, одоо энэ шинэ гарч байгаа жилдээ энэ тал дээр анхаараач ээ гэж би хэлмээр байна.



Тэгэхээр магадгүй энэ тухайд мэдээж хэрэг хуулийн дагуу та нар ажиллахаас арга байхгүй. Гэхдээ тэр хуульд өөрчлөлт оруулах байдаг юм уу, магадгүй энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд бид бас арай өөр хандлагаас ёс зүйн соёлыг хэвшүүлэх, энэ тал дээр хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлууд бид нарт яригдах байх л даа.

Тэгэхээр хандлагыг нь өөрчлөх, харах хүн онцгүй өөрчилж ажиллах тал дээр Та бүхнийг цаашид анхаараасай гэж хэлмээр байна.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Гишүүдийн санал асуултад бас нэлээд анхааралтай хандаж цаашдынхаа үйл ажиллагаанд мөрдлөг болгоорой гэдгийг Та бүхэнд хэлье.

Ер нь бол манай Ёс зүй дэгийн байнгын хороо, харьяа Монгол Улсын Ёс зүйн хороо, доор нь байгаа дэд хороод.

Тэгээд бид ер нь нэг тийм амар асуудлыг бас шийдэх гээд байгаа зүйл биш шүү дээ. Ер нь бол.

Өнөөдөр манай нийгэм өөрөө ёс суртахууны доройтолд хэдий хэрийн хэмжээнд ортлоо явчихсан байгаа билээ. Тэгээд бид энэ нөхцөл байдлаас төрийн албан хаагчаараа дамжуулж л энэ ёс суртахууныг түгээнэ л гэж, ёс зүйг төлөвшүүлнэ л гэж зорилго болгоод ажиллаж байгаа.

Соён гэгээрүүлэх ажил хамгийн чухал, сэтгэлгээний өөрчлөлт хамгийн чухал, хандлага өөрөө хамгийн чухал. Эцэст нь хариуцлага.

Тэгээд шинэ тутамдаа байгуулагдаж байгаа байгууллагууд л даа. Монгол Улсын Ёс зүйн хороо, дэд хороодууд. Бас нэг зүгширч, бас нэг чигээ олтол бас нэг жоохон хугацаа хэрэгтэй болов уу.

Энд манай Байнгын хороо хууль эрх зүйн хувьд ч тэр, арга зүйн хувьд ч тэр нэлээн өндөр түвшинд дэмжлэг үзүүлж ажиллах ёстой гэж харж байгаа. Ажиллах боломж бололцоогоор нь хангаж өгөх ёстой. Ямар ч байсан сая нэг байр өргөтгөөд 2 өрөө нэмээд 3 өрөө нэмж авч өгсөн. Ажиллах боломж бололцоо бас дагаад сайжирч байгаа болов уу гэж харж байгаа.

Дараагийн асуудал энэ “ёс суртахуун”, “ёс зүй” гэдэг асуудлаа жоохон ялгаж салгана шүү.

Бид зүгээр хоёр хүний хоорондын харилцааны асуудлыг шүүдэг байгууллага биш шүү. Хэрвээ тэрийг шүүх юм бол энэ асуудал цэгцрэхгүй. Өнөөдөр төрийн албан хаагч шат шатандаа өнөөдөр хууль зөрчихгүй л байх ёстой, ашиг сонирхол давтахгүй л байх ёстой, би авлига авч болохгүй шүү дээ

гэдгийг мэдсээр байж байж авч байгаа бол энэ ёс зүйн алдаа, цаашлаад эрүүгийн зөрчил, гэмт хэрэг.

Би ашиг сонирхлыг өнөөдөр энэ хувийн ашиг сонирхлыг илүү давамгайл тавьж болохгүй шүү дээ гэдгийг мэдсээр байж зөрчиж байгаа бол энэ ёс зүйн зөрчил. Түүнээс тэр хоёр хүний хоорондын харилцааны асуудал бол ёс суртахууны асуудал шүү.

Одоо энэ өргөдөл, гомдлын дийлэнх нь л харилцааны асуудал байгаа л даа. Үүний цаана нөгөө хүнд суртал гэж яригдаад байгаа зүйл чинь байхгүй юу. Төрийн албаны хүнд суртал. Ялангуяа түрүүн А.Ариунзаяа гишүүн их тодорхой хэлсэн шүү дээ. Иргэдэд үйлчилдэг үйлчилгээний байгууллага бол хүнд суртал өндөр байдаг юм шүү. Бид ч үйлчлүүлдэг шүү дээ. Түүгээр байнга л явж байгаа шүү дээ. Сүүлийн үед нь цахим яамтай болоод бид чинь харин зарим төрийн үйлчилгээг цахимаар авдаг болсноор харьцангуй хүнд суртал буурч байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр төрийн албаны үнэт зүйл өөрөө юу юм бэ гэдэг нь бол ёс зүй. Ерөөсөө л төрийн албаны үнэт зүйл бол ёс зүй. Энэ ёс зүй нь дотроо яах ёстой юм бэ гэвэл хуулиа л мөрдөж ажиллах ёстой. Мэдээж ёс зүй олон онолууд байдаг л даа. Утилитар онол гээд л. Зарим тохиолдолд хуулийг мөрдөхгүй байх хэмжээний асуудлыг хүртэл ёс зүй дээр ярьдаг шүү дээ.

Тэгэхдээ бид өнөөдөр нэг ийм баригддаггүй мөнгөн усны талаар яриад байгаа байхгүй юу. Нэг талаас нь харахаар ёс зүйн зөрчил мөн ч юм шиг, нөгөө талаас нь харахаар биш ч юм шиг.

Яг барьж аваад асуудалд нь хандчихъя гэхээр. Магадгүй бидний тооцож байгаа хариуцлагын асуудал нэг талдаа сул мэт харагдаж байгаа боловч нөгөө талдаа яг хариуцлага тооцуулж байгаа хүндээ ямар байдгийг бид мэдэхгүй байна.

Дээр нь өнөөдөр манай Ёс зүйн хороо тэр төрийн өмчит компанийн удирдлагууд орж ирж байгаа нэг сайн хэрэг. Улс төрийн албан тушаалтнууд орж байгаа нь давуу тал. Төрийн албаны зөвлөл энэ болгон руу орох боломж байхгүй. Ёс зүй оровол энэ зүйл рүү орж байгаа. Орж байгаа.

Тэгэхээр өнөөдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай холбогдуулаад өнөөдөр тайлан хэлэлцэж байгаа.

Хяналт шалгалтын газраас үнэлгээ, мониторинг гарах ёстой. Байнгын хороо үндэслэж шийдвэр, тогтоолыг гаргана гэж үзэж байгаа.

Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүд Та бүхэндээ баярлалаа.

Тайланг бид ямар ч байсан сонсож, асуулт асууж, үг хэллээ.

Байнгын хорооны шийдвэртэй холбогдуулж саяын миний хэлсэн хоёр хуультай уялдуулан тогтоол, шийдвэрийг гаргах зайлшгүй шаардлага байгаа учраас шийдвэрийг хаврын чуулганаар гаргана.

Хаврын чуулганы цаг үе дээр дахиж Байнгын хороо хэлэлцэж Улсын Их Хурлын хяналт шалгалтын газраас орж ирэх үнэлгээ, мониторингтой уялдуулан дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуультай уялдуулан шийдвэрийг хаврын чуулганаар хэлэлцэж батална гэдгийг Та бүхэндээ хэлье.

Ингээд өнөөдрийн эхний асуудлыг сонслоо. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орно.

---

### **Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл**

/Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай/

---

Улсын Их Хурлын гишүүн, Монгол ёс зүй дэгийн байнгын хорооны гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг 2024 оны 10 сарын 24-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын биеэ даасан хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан ирсэн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Б.Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ш.Батсүх Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн, Удирдлагын академийн багш, доктор, С.Бат-Орших Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш. Байна уу? Н.Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга гэсэн ийм ажлын хэсэг.

Саяын нэгдүгээр асуудалд орсон ажлын хэсэг үргэлжлүүлээд сууж байна гэж ойлгож болно.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

---

**Х.Баасанжаргал:** Монгол Улсын Их Хурлын Ёс зүй дэгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийн санал, дүгнэлт хэсгийг уншиж танилцуулъя.

Гэхдээ түүнээсээ өмнө бас товчхон энэ санал, дүгнэлтийг гаргахын тулд хаана, хаана, ямар байгууллагууд ямар процессоор ямар зарчмыг баримталж ажилласан бэ гэдгээ бас товчхон хэлж танилцуулъя.

Ёс зүйн хороо болон Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцах. Тэр дундаа орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцах хүрээнд Увс аймаг болон Өвөрхангай аймгийн төрийн байгууллага, төрийн албан хаагчид, мөн тусгай чиг үүргийн байгууллагууд зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа, ажилтан, албан хаагчидтай уулзаж ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцсан.

Түүнээс гадна Улаанбаатар хотод Сонгинохайрхан дүүргийн Тамгын газрын үйл ажиллагаатай танилцсан.

Мөн бидний ажлын хэсгийн нэг гол чиг үүрэг Ёс зүйн хорооны бие даасан байдлын ийм асуудал байгаа.

Тийм учраас ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын үйл ажиллагаатай танилцах замаар бас яг энэ Ёс зүйн хорооны үйл ажиллагааг цаашид анхаарах, ялангуяа хууль тогтоомжийн хүрээнд бодлогын түвшинд анхаарах ёстой зүйлүүдийг бас харьцуулж судлан гаргах зорилгоор Шүүхийн сахилгын хороо, мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэсэн ийм хоёр хороод, зөвлөлийн үйл аж ажиллагаатай танилцсан.

Эдгээр хоёр зөвлөл нь хоёулаа яг Монгол Улсын Ёс зүйн хороотой ижилхэн орон тооны бус гэдэг ийм статустай үйл ажиллагаа явуулж байгаад ингээд 2019 оноос эхлээд орон тооны үйл ажиллагаатай. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2023 оноос эхлээд бүтэн орон тооны гишүүдээр бүрдэж ингэж үйл ажиллагаагаа явуулж байсан ийм зүйл харагдсан.

Ингээд эдгээр зүйлтэй холбоотой санал, дүгнэлтийн хэсгээ Та бүхэнд танилцуулъя.

Санал, дүгнэлтийг гаргахдаа бид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу бодлогын түвшний санал, дүгнэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшинд гэсэн нэг ийм хоёр хэсэгт гаргасан. Ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ёс зүйн дэд хороодын хувьд хууль тогтоомжийн хэрэглээний тодорхойгүй байдал маш их байсан учраас бас ингэж бодлогын асуудлыг тусад нь салгаж танилцуулж байгаа юм гэдгийг Та бүхэнд танилцуулъя.

Түүнээс гадна шинээр байгуулагдсан Ёс зүйн хорооны үйл ажиллагааны үр нөлөөтэй байх. Цоо шинэ энэ тогтолцоо өөрөө анхнаасаа иргэд төдийгүй

төрийн албан хаагчдынхаа дунд нэр хүнтэйгээр үйл ажиллагаа явуулах, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой гэдэг зарчмыг баримталж бид энэ ёс зүйн дүгнэлтийг гаргасан.

Тэгэхээр цаашид энэ Ёс зүйн хороонд тавьж байгаа иргэдийн бас итгэл, хүлээлт нэлээн өндөр байгаа учраас энэ хорооны үйл ажиллагааг цаашид хэрхэн яаж тогтвортой нэр хүндтэй байх вэ гэдэг талаас илүү санал, дүгнэлтээ боловсрууллаа.

Бодлогын хүрээнд нэгдүгээрт энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах. Тэр дундаа Ёс зүйн хорооны гишүүдийн бие даасан байдалд анхаарч, Их Хурлаас нээлттэй сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлэх замаар нэг удаа бүрэн эрхийн хугацаанд ажилладаг байх гэдэг ийм санал оруулж байгаа.

Манай Их хурлын гишүүд ч гэсэн сая бас анзаарч байгаа байх. Санхүүгийн зохицуулах хорооны, Монголбанкны гээд эдгээр хороодын зөвлөлийн гишүүдийг, мөн Хяналтын зөвлөлийн гишүүдийг бид бүгдээрээ дандаа Их Хурлаар нээлттэй сонгон шалгаруулалтаар оруулж нэр дэвшүүлж сонгож байгаа.

Тэгэхээр энэ процесс зайлшгүй энэ хороонд байх ёстой гэж харсан.

Хоёрдугаарт, улс төрийн болон төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор нарийвчлан зааглах шаардлагатай байна.

Түрүүн Д.Энхтуяа гишүүн хэлсэн. Ялангуяа төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн албан тушаалтантай холбоотой ёс зүйн асуудал дээр хууль тогтоомжийг нарийвчлах шаардлагатай.

Мөн Та бүхэнд сая танилцуулсан илтгэл, тайлан дээр төрийн өндөр албан тушаалтантай холбоотой гомдлыг Монгол Улсын Ёс зүйн хороо шийдэж байгаа. Одоогийн байдлаар нэг л гомдол шийдсэн байдалтай байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ нь эргээд нөгөө талдаа яг төрийн албан хаагч дээр, анхан шатын нэгж дээр ялангуяа ажиллаж байгаа төрийн албан хаагчдын хувьд бид нарт л энэ хууль чинь үйлчлээд байна. Нөгөө төрийн өндөр албан тушаалтанд энэ хууль яагаад үйлчлэхгүй байгаа юм бэ гэдэг асуудлыг бол зүй ёсоор тавьж эхэлж байгаа гэсэн үг.

Тэгэхээр үүнтэй холбоотой асуудлыг нэлээн нарийвчлах шаардлагатай байна.

Дээрээс нь мөн Ажлын хэсэгт Засгийн газрын Ёс зүйн дэд хороо ажлаа тайлагнасан. Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо мөн үйл ажиллагааны хувьд бас хууль тогтоомжийн тодорхойгүй, хийдэлтэй ийм нөхцөл байдлаас

болоод бас зарим нэг зүйлүүд давхардал хийдэл байсан гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Гуравдугаарт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэгээрүүлэх соён гэгээрүүлэх ажил хамгийн чухал чиг үүрэг нь байгаа. Энэ Ёс зүйн хороодоос. Бусад Шүүхийн сахилгын хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дэргэдэх хороодуудад ийм чиг үүрэг огт байхгүй. Түүгээрээ манай Монгол Улсын Ёс зүйн хороо ялгаатай.

Энэ агуулгаараа бид ёс зүйн хөтөлбөр, сургалтын хөтөлбөр маш их хэрэгцээ шаардлага өндөр байгаа нь ялангуяа орон нутагт ажиглагдаж байсан. Орон нутгийн хувьд харилцан адилгүй сургалтын хөтөлбөрөө өөр өөрсдийнхөө байгаа нөөц бололцоондоо тулгуурлаад салбар бүр харилцан адилгүй ёс зүйн сургалтыг явуулж байгаа нь ажиглагдсан.

Тэгэхээр тухайн орон нутгийн удирдлагын санаачилгатай байдлаас нэлээн хамаарч байгаа учраас сургалтын үйл ажиллагаа цаашид нэлээн системтэй явагдах байх гэж найдаж байна. Сая илтгэл тайлан дээр нэлээн системчилж байгаа гэдэг зүйлийг тайлан дээр яригдлаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Дөрөвдүгээрт, бас нэг чухал зүйл нь маш их давхардал үүсэж байна гэдэг ийм гомдлыг орон нутагт илэрхийлж байсан. Орон нутгаас гадна онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг хууль сахиулах гээд тусгай чиг үүргийн байгууллагууд дээр тэртээ тэргүй салбарын мэргэжлийн өөрийнх нь ёс зүйн дүрэм байгаад байдаг. Түүнтэй зэрэгцээд дахиад хоёр дахь ийм Ёс зүйн дэд хороо дахиад байгуулаад. Өөрөөр хэлбэл юу гэдэг юм Увс аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр хоёр Ёс зүйн хороо ажиллаж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ байдал нь өөрөө хууль тогтоомжийн хэрэглээний хувьд бөгөөд дээрээс нь ёс зүйн механизм үнэхээр чухал юм гэдэг энэ хүлээлт, итгэл найдварыг жаахан сөрөг нөлөө үзүүлээд байна гэж харж байгаа.

Тэгэхээр энэ салбарын хууль тогтоомжтой уялдуулах, ялангуяа бусад салбарууд дээр манай Байнгын хорооноос 2023 онд 2 удаа тогтоол гаргасан байгаа. Засгийн газарт чиглэл өгсөн. Энэ Засгийн газрын тогтоол ерөөсөө хэрэгжихгүй байна гэж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр бүр онцгой анхаарахгүй бол эргээд төрийн албан хаагчид маань энэ механизмд итгэхээ больчихвол бид дахин сэргээж чадахгүй.

Тэгэхээр ийм шинэ механизмаа бид яаж хамгаалах вэ, яаж дархлаатай байх вэ гэдэг дээр Засгийн газартай маш ойр, Засгийн газрын хийх ёстой ажлууд байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэгээд хамгийн сүүлд түрүүн Б.Хэрлэн гишүүн хэлсэн. Ёс зүйн манлайлал үзүүлж байгаа гишүүдтэй холбоотой ер нь урамшууллын механизм огт байхгүй. Эвлэрүүлэн зуучлалын механизм энэ хууль дээр огт байхгүй байгаа. Ихэвчлэн хүмүүс гомдол гаргадаг хэдий ч гэсэндээ яг бодит байдал дээр талууд хоорондоо ялангуяа удирдах, удирдуулах албан тушаалтны хувьд ч гэдэг юм уу ихэвчлэн гомдлыг илүү эвлэрч хоорондоо асуудлаа ярьж тохиролцоод бие биеэсээ уучлал гуйх замаар бас асуудал хааж байгаа ийм дүр зураг нэлээн ажиглагдаж байгаа.

Тэгэхээр зарим нэг процессын хэм хэмжээг энэ хууль дээр нарийвчлах ёстой байна. Тэгэхгүй бол одоо цаашид манай Ёс зүйн хороо төрийн албан хаагчийг томилох, албан тушаал ахих гээд энэ зүйлүүд дээр ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн үзүүлэлтүүдийг нь харгалзаж үздэг болно гээд байгаа юм.

Тэгэхээр эргээд төрийн албан хаагчдын маань эрх зүйн байдал дордохгүй байх ёстой. Дээрээс нь энэ ёс зүйн индекс өөрөө үр нөлөөтэй ажилладаг байх ёстой.

Тэгэхээр энэ процессын хэм хэмжээний хувьд нэлээн нарийвчлах хэрэгцээ шаардлагууд байна гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд би түрүүн хэлсэн. Сургалтын асуудал, хэрэгцээ шаардлага маш өндөр байгааг анхаарах хэрэгтэй. Түүнтэйгээ зэрэгцүүлээд төрийн албан хаагчдынхаа ёс зүйн сургалтын агуулгаа бид нэлээн өндөр түвшинд гаргах хэрэгтэй. Маш энгийн, маш элементарный, маш юу гэдэг юм наад захын харилцааны ийм асуудлууд гэхээсээ илүүтэй ёс зүйн түвшнээ бид өндөрт барихад энэ сургалтын агуулгыг анхаараасай гэж хүсэж байгаа гэсэн үг.

Мөн төрийн өндөр албан тушаалтан, удирдах албан тушаалтантай холбоотой ёс зүйн хариуцлага хүлээлгэж байгаа мэдээллийг нийтэд ил тод зарлах зүйл жаахан дутагдалтай байна уу гэж харж байгаа.

Ёс зүйн хороо болоод дэд хороо гэдэг одоогийн бүтэцтэй явж байгаа.

Тэгэхээр одоо жишээ нь, аймгийн хэмжээнд гэхэд 150, 160 орчим Ёс зүйн дэд хороо байгуулагдаад ингээд нэг аймаг дээр байгаа 150, 160 дэд хороод маань шууд Ёс зүйн хороонд тайлан мэдээллээ өгч байгаа.

Тэгэхээр аймаг, орон нутгийн хэмжээнд уялдуулах ерөөсөө механизм байхгүй байна гэж харж байгаа.

Тэгэхээр бүтцийн хувьд бид зайлшгүй эргэж харах ёстой зүйлүүд байна. Дээрээс нь сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зарим төрийн байгууллагуудынхаа хүний нөөцтэй уялдуулах ийм хэрэгцээ шаардлага байна.

Босоо удирдлагатай системийн хувьд одоо жишээ нь улсын бүртгэлийн хувьд улсын бүртгэгч ёс зүйн асуудал гаргалаа гэхэд Улаанбаатар хотод байгаа



Улсын бүртгэлийн ерөнхий газар нь тэнд очиж ажиллахгүй байна. Аймаг орон нутгийн удирдлагууд л яг энэ асуудал дээр нүүр тулж байна.

Тэгэхээр энэ асуудлыг бид бүр яг тогтолцооны хувьд хууль тогтоомжоо эргэж сайжруулах, үр нөлөөг тодорхой аргачлалын дагуу хийх тохиолдолд энэ бүтцийн зүйлийг зайлшгүй эргэж харах ёстой байгаа гэдгийг нэмж хэрэглэх ёстой байх.

Тэгээд урамшууллын асуудал маш хангалтгүй байна.

Түрүүн Г.Очирбат гишүүн бас асуулт дээрээ асуусан. Хэд нь урамшуулал аваад хэд нь урамшуулал авахгүй байгаа юм бэ гэдэг дээр харилцан адилгүй хэрэглээтэй байна. Зарим Ёс зүйн хороо байгуулагдсан гэдгээр нь гишүүдийн урамшууллуудыг олгоод явж байна. Зарим аймаг. Одоо жишээ нь, Өвөрхангай аймгийн хувьд зөвхөн байгуулагдсан гэдгээр урамшуулал авахгүй. Ядаж төлөвлөгөөгөө батал гээд ингээд ийм ажлын үр дүн шаардах замаар зарим нь урамшууллаа олгож явж байна.

Гэх мэтээр урамшууллын асуудал дээр харилцан адилгүй, ойлголтын зөрүү байгаа учраас энэ дээр манай Ёс зүйн хороо маань өөрөө мэргэжил арга зүйн удирдлагаар хангаад энэ асуудал дээр нэгдмэл ойлголттой болохгүй бол цаашид Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллах төрийн албан хаагчид олдохгүй болох вий гэдэг ийм болгоомжлол байгаа.

Нэлээн хэдэн байгууллага дээр би одоо энэ Ёс зүйн дэд хорооны ажлаа өгмөөр байна. Өөр хүнд өгөх гэхээр энэ ажлыг авах хүн байхгүй байна гэдэг ийм асуудалтай бид яг нүүр тулсан.

Тэгэхээр энэ хүнийг тэгж ийм халшраадаг ийм ажил бол байх ёсгүй. Тэгэх юм бол дахиад л манай ёс зүйн энэ шинэ механизм ажиллахгүй болно гэсэн үг.

Тэгэхээр ийм ийм зүйлүүд дээрээ анхаарах замаар бид энэ санал, дүгнэлтээ гаргалаа. Тэгээд санал, дүгнэлт нэлээн дэлгэрэнгүй гарсан. Бас санаа авах, харьцуулан цаашид судлах үүднээс бас ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ийм хороодын мэдээллийг давхар оруулсан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Х.Баасанжаргал гишүүн ажлын хэсгийн даргад баярлалаа.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд. А.Ариунзаяа гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Би өөрөө ажлын хэсэгт орсон учраас би асуулт асуухгүй. Би зүгээр дахиад л энэ урамшуулалтай холбоотой Х.Баасанжаргал гишүүний танилцуулгатай холбоотой бас нэг үг хэлэх гэсэн юм.



Яагаад гэвэл яг энэ урамшуулалтай хороонд орж ажилласны. Тийм ээ. Энэ бол ямар ч хороо байсан бай орж ажилласны урамшуулалыг олгохгүй байх Хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулахад ч гэсэн би тухайн үед хэлж байсан.

Энэ чинь ямар нэгэн байдлаар илүү айхтар, өндөр цалин хөлс аваад л, нэг их айхтар илүү эрх эдлээд байгаа асуудал огт биш. Харин хийж байгаа ажлынхаа хажуугаар нь одоо бас яг энэ хороонд олгогдсон байгаа чиг үүргийг давхар хийж байгаа учраас тодорхой хэмжээний бага зэргийн урамшуулал бас олгож байсныг төрийн өмчит компаниудын дэргэд байгаа өөр хороонуудтай зүйрлэж их өндөр цалин аваад л зүгээр л сууж байгаад л өндөр урамшуулал аваад байгаа юм шиг хольж хутган бүхий л энэ хороонд урамшуулал өгөхгүй гэдэг ийм хуулийг хэдүүлээ баталчихсан.

Тэгэхээр магадгүй бид дахиад дүгнэлт гаргаж байгаа юм чинь энэ хэмнэлтийн тухай хуулийг эргэж харах, тодорхой хэмжээнд уян хатан болгохгүй хэт туйлширсан төрийн шийдвэрүүд төрийн албан хаагчдын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд их хүндрэлийг учруулдаг юм шүү гэдгийг ташрамд хэлэх гэсэн юм. Тэгээд Хэмнэлтийн тухай хуульд олон засаж залруулах зүйл, заалтууд байгаа.

Манай төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотойгоор бид санал гаргаж явах юм чинь яг энэ хороодын урамшуулалтай холбоотойгоор эргэж харж үзэхгүй бол яг Х.Баасанжаргал гишүүний хэлсэнчлэн байгаа ажлынхаа хажуугаар ийм чиг үүргийг хүлээгээд, тэгээд ажиллах хүн хүмүүс ер нь хомс байгаа гэдгийг онцлон хэлье.

**Б.Баярбаатар:** Асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Х.Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн хамт олонд баярлалаа. Ажлын хэсэг маш сайн ажилласан. Цаашлаад нарийвчлаад судалгаа хийх, үйл ажиллагааг боловсронгуй болгох, илүү ойлгомжтой болгох, илүү хялбар болгох ийм шаардлага өнөөдөр байгаа. Жишээлбэл, би түрүүн хэлсэн шүү дээ. Хоёр хүний маргааныг шийдээд байх юм бол бидний ажил явахгүй гэж.

Тэгэхээр зарим энэ дэд хороодын асуудлуудыг бид ер нь эргэж харах ёстой юм шиг байна. Зарим аймгууд дээр.

Нэгдүгээрт, хууль эрх зүйн зохицуулалтаа бид дахиж сайжруулах зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа. Бусдад дараа түвэг удах асуудлыг бий болгоод байж болохгүй байхгүй юу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би тэр харилцааны асуудал шийдэхгүй болно гэдэг чинь өөрөө нөгөө хүн халшрахгүй хэмжээ рүү очно гэсэн үг. Хуулиа л барьж ажиллая хэдүүлээ. Хуулийн дагуу асуудалдаа хандъя.

Гуравдугаарт нь, сургалтын асуудал. Соён гэгээрүүлэх сургалтын асуудал өөрөө их чухал.

Тэгэхээр нэг ийм тунг нь тааруулсан ажил л шаардлага байгаа юм даа. Хэт ингэж туйлширч болдоггүй, хэт бас ингэж хумьж болохгүй. Яаж энэ нэг тунг нь хэдүүлээ нэг тааруулж ажиллах вэ гэдэг дээр л зайлшгүй шаардлага байгаа.

Тэгээд би энэ ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье. Үргэлжлүүлж энэ ажлын хэсэг бас. Одоо өнөөдөр Байнгын хорооноос шийдвэр гарна. Үргэлжлүүлээд энэ хууль эрх зүйн орчноо сайжруулах тал дээр манай Байнгын хороо үргэлжлүүлээд ажиллах зайлшгүй шаардлага үүсэж байгаа гэдгийг бас хэлье.

Асуулт асууж үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос тогтоол гарна. Тогтоолын төслийг би Та бүхэнд уншиж танилцуулъя.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын биеэ даасан хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Ёс зүйн хороо Ц.Амартөгсөд даалгасгай.

1/Төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалт, соён, гэгээрүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, тасралтгүй зохион байгуулж үнэлэх.

2/Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа, сургалтын төлөвлөлт, тайлагнал, гомдол, мэдээлэл, зөрчил, хариуцлагын нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулж, тогтмол хэрэглээг хэвшүүлэх.

3/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалтын агуулга, хөтөлбөрт нийцсэн цахим болон танхимын сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн боловсруулах үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулах.

4/Төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээрх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, үр дүнг тайлагнах.

5/Мэргэжлийн ёс зүйн дүрэм, давхардал, хийдлийг арилгах арга хэмжээг эрчимжүүлэх, тусгай чиг үүргийн байгууллагын ёс зүйн дэд хороог хэрхэн зохион байгуул болох талаар судалж, саналаа ирүүлэх.

6/Салбар болон мэргэжлийн ёс зүйн чиглэлээр хууль тогтоомжийн судалгаа хийлгэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг танилцуулах.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын биеэ даасан хараат бус ажиллах нөхцөл, чиг үүргийг гомдол мэдээллийн харьяаллын тогтоох, зохицуулалтыг боловсронгуй болгох, уг хуулийн хэрэгжилтийг үр дагаврын үнэлгээ болон холбогдох судалгааг хийлгэж, хуулийн төсөл боловсруулж Улс Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхээр тогтсугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо Б.Баярбаатарт даалгасугай гэсэн ийм 3 зүйл, заалт бүхий тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Тэгвэл тогтоолын төслөө баталъя гэдэг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 9 гишүүн оролцож, 6 гишүүн буюу 66.7 хувиар тогтоол батлагдлаа.

Дүгэрийн Рэгдэл гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн хоёр дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Ж.Батсуурь гишүүнийг бас дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Хурлын хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна.

Хурлын төгсгөлд би Ёс зүй дэгийн байнгын хорооны гишүүдтэй бас Ёс зүйн хорооны гишүүд байж байна.

Ер нь ингээд цаашдаа бид бол илүү хичээж, илүү хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлага байна гэдгийг өнөөдрийн тайлангаас, сая манай Байнгын хорооноос байгуулагдаж ажилласан ажлын хэсгийн дүгнэлтээс хангалттай мэдрэмж, ойлголтыг авлаа гэж хэлж болно.

Дээр нь Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 126 гишүүнтэй парламентын анхны ээлжит чуулган энэ долоо хоногт завсарлах болов уу гэж харж байна. Чуулган завсарлах явцад энэ ирцтэй холбоотой мэдээллийг манай Байнгын хорооны гишүүд А.Ариунзаяа гишүүн хариуцаад яг ирцтэй холбоотой мэдээллийг нарийвчилж гаргах зайлшгүй шаардлага байна.

Хуралдаа суудаггүй гишүүд байна. Халтмаагийн Баттулга, Сүрэнжавын Лүндэг. Нийгэм өнөөдөр энэ хуралдаа суухгүй байгаа гишүүд рүү чинь онцгой анхаарал хандуулж байна.

Энэ хууль тогтоох байгууллагад төлөөллийн ардчилалыг хангаж сонгогдож ирсэн юм бол хуралдаа сууж байх ёстой. Энэ хүний ажил, энэ хүний үүрэг.

Тийм учраас Байнгын хорооны зарим гишүүд, А.Ариунзаяа гишүүн энэ ирцийн нарийвчилсан мэдээллийг оруулж ирээд шаардлагатай бол дараагийн хуралд Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн дагуу хариуцлага тооцох саналыг оруулж ирээрэй гэж би Та бүхэндээ хэлье.

Өнөөдрийн хурал дууссаныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 15 цаг 22 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**